



УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

СТРАТЕГИ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

2019 I-VIII

I. УУЛ УУРХАЙН САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ ОРУУЛСАН ТАТВАР, ХУРААМЖ	1
II. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР	2
II.1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл.....	2
II.2. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....	3
II.3. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн.....	3
III. ГАДААД ХУДАЛДАА	4
III.1. Экспорт	4
III.2. Импорт.....	5

I. УУЛ УУРХАЙН САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ ОРУУЛСАН ТАТВАР, ХУРААМЖ

2018 оны жилийн эцсийн байдлаар улсын төсөвт **2,051.5** тэрбум

төгрөгийг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **80.0** тэрбум төгрөг,
- Нүүрс **910.6** тэрбум төгрөг,
- Цайр **76.9** тэрбум төгрөг,
- Зэс **871.9** тэрбум төгрөг,
- Төмөр **17.1** тэрбум төгрөг,
- Жонш **16.3** тэрбум төгрөг,
- Бусад **78.8** тэрбум төгрөг,

Улсын төсөвт орсон орлогыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **456.3** тэрбум төгрөг буюу **28.6** хувиар өссөн. Үүнээс:

- Алт **31.0 (63.1%)** тэрбум төгрөг,
- Нүүрс **306.8 (50.8%)** тэрбум төгрөг,
- Цайр **13.6 (21.5%)** тэрбум төгрөг,
- Зэс **71.1 (8.9%)** тэрбум төгрөг,
- Төмөр **4.7 (38.6%)** тэрбум төгрөг,
- Жонш **4.0 (32.1%)** тэрбум төгрөг,
- Бусад **25.0 (46.5%)** тэрбум төгрөг.

2019 оны эхний 8 сарын байдлаар улсын төсөвт **1.8** их наяд төгрөг татвар,

хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **26.8** тэрбум төгрөг,
- Нүүрс **872.6** тэрбум төгрөг,
- Цайр **55.6** тэрбум төгрөг,
- Зэс **775.4** тэрбум төгрөг,
- Төмөр **17.4** тэрбум төгрөг,
- Жонш **22.3** тэрбум төгрөг,
- Бусад **48.1** тэрбум төгрөг,

Улсын төсөвт оруулсан орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **377.9** тэрбум төгрөг буюу **26.2** хувиар өссөн байна. Үүнд:

- Нүүрс **279.4(47.1%)** тэрбум төгрөг,
- Зэс **106.6 (15.9%)** тэрбум төгрөг,
- Төмөр **4.7 (37.3%)** тэрбум төгрөг,
- Жонш **11.5(106.3%)** тэрбум төгрөг,

Харин дараах ашигт малтмалын татвар, хураамж буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Алт **17.8(40.0%)** тэрбум төгрөг,
- Цайр **4.6(7.6%)** тэрбум төгрөг,
- Бусад **1.9(3.9%)** тэрбум төгрөг.

Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, ашигт малтмалаар

тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018		2019		Өөрчлөлт			
	VIII	I-VIII	VIII	I-VIII	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийтдүн	99.5	1,440.4	156.1	1,818.3	56.6	56.9%	377.9	26.2%
Алт	8.6	44.6	4.6	26.8	-4.1	-47.2%	(17.8)	-40.0%
Нүүрс	34.9	593.2	83.9	872.6	49.0	140.7%	279.4	47.1%
Цайр	4.9	60.2	2.0	55.6	-2.9	-59.4%	(4.6)	-7.6%
Зэс	43.6	668.8	52.3	775.4	8.7	19.9%	106.6	15.9%
Төмөр	3.2	12.7	2.9	17.4	-0.3	-10.5%	4.7	37.3%
Жонш	1.2	10.8	3.3	22.3	2.2	2.8 ¹	11.5	2.1 ¹
Бусад	3.1	50.0	7.1	48.1	4.1	2.3 ¹	-1.9	-3.9%

Тайлбар: 1 - дахин их

II. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР**II.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ**

2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр **34.1 сая тн** нүүрс, **878.7мян.тн** зэсийн баяжмал, **9.5тн** алт, **3.5мян.тн** молибдений баяжмал, **81.5мян.тн** хайлуур жоншны хүдэр,**34.2мян.тн** хайлуур жоншны баяжмал,**5.4сая тн** төмрийн хүдэр,**2.1сая тн** төмрийн хүдрийн баяжмал,**55.9мян.тн** цайрын баяжмал,**4.6сая бар** газрын тос, **8.2мян.тн** катодын зэс тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс **4.7сая тн** буюу **16.1** хувь,зэсийн баяжмал**18.3мян.тн** буюу **2.1** хувь,төмрийн хүдэр **1.4сая.тн** буюу **36.0** хувь,төмрийн хүдрийн баяжмал **150.9мян.тн** буюу **7.9** хувь,хайлуур жоншны хүдэр **3.9** мян.тн буюу **5.0** хувь, цайрын баяжмал **0.2мян.тн** буюу **0.4** хувь, газрын тос **58.3мян.бар** буюу **1.3** хувиар тус тус өссөн байна.

Харин алт **2.4тн**буюу **20.5** хувь, молибдены баяжмал **171.6тн** буюу **4.7** хувь,хайлуур жоншны баяжмал **10.1** мян.тн буюу **22.8** хувь, катодын зэс **1.4мян.тн** буюу **14.2** хувиар тус тус буурсан байна.

№	Бүтээгдэхүүнийтөрөл	Хэмжихнэгж	2018		2019		Өөрчлөлт			
			VIII	I-VIII	VIII	I-VIII	(5-3)=?, (5/3)=%	(6-4)=?, (6/4)=%	7	8
	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Уулуурхай, олборлохажүйдвэр									
1.1	Нүүрс	мян.тн	3,054.9	29,387.1	4,994.2	34,112.3	1,939.3	63.5%	4,725.2	16.1%
1.2	Газрынтос	мян.бар	553.2	4,494.4	589.7	4,552.7	36.5	6.6%	58.3	1.3%
1.3	Зэсийнбаяжмал, м/агуулгаараа	мян.тн	100.1	860.4	95.8	878.7	-4.3	-4.3%	18.3	2.1%
1.4	Молибденийбаяжмал, м/ агуулгаараа	тн	486.1	3,623.1	443.6	3,451.5	-42.5	-8.7%	-171.6	-4.7%
1.5	Алт	кг	2,741.5	11,947.0	1,876.9	9,499.6	-864.6	-31.5%	-2,447.4	-20.5%
1.6	Төмөр:									
	- Төмрийнхүдэр	мян.тн	625.4	3,998.0	751.3	5,436.9	125.9	20.1%	1,438.9	36.0%
	- Төмрийнхүдрийнбаяжмал	мян.тн	239.7	1,906.5	294.9	2,057.4	55.2	23.0%	150.9	7.9%
1.7	Хайлууржонш:									
	- Хайлууржоншны хүдэр	мян.тн	7.8	77.6	7.9	81.5	0.1	1.3%	3.9	5.0%
	- Хайлууржоншныбаяжмал	мян.тн	3.7	44.3	7.1	34.2	3.4	91.9%	-10.1	-22.8%
1.8	Цайрынбаяжмал	мян.тн	8.9	55.7	5.6	55.9	-3.3	-37.1%	0.2	0.4%
2	Боловсруулах ажүйдвэр									
2.1	Катодынзэс, 99%	тн	1,237.8	9,603.2	961.4	8,236.6	-276.4	-22.3%	-1,366.6	-14.2%
2.2	Металлбэлдэц	тн	1,583.9	18,373.8	805.1	20,048.6	-778.8	-49.2%	1,674.8	9.1%
2.3	Металлцувимал	тн	1,596.5	20,113.8	1,603.0	20,274.5	6.5	0.4%	160.7	0.8%

Эх сурвалж: УСХ

II.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

Салбар	2018		2019		Өөрчлөлт			
	VIII	I-VIII	VIII	I-VIII	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийтдүн	1,261.0	9,909.6	1,594.9	11,445.5	333.9	26.5%	1,536.0	15.5%
Уулуурхай, олборлохажүйлдвэр	910.3	7,097.8	1,210.6	8,315.8	300.2	33.0%	1,218.0	17.2%
Нүүрсолборлолт	249.5	2,404.6	554.0	3,587.2	304.5	122.0%	1,182.5	49.2%
Газрынтосолборлолт	91.2	712.5	84.8	677.4	-6.4	-7.0%	-35.2	-4.9%
Металлынхүдэрлборлолт	560.6	3,892.2	554.2	3,952.2	-6.4	-1.1%	60.0	1.5%
Бусадашингтмалтмалолборлолт	9.0	88.4	17.5	99.1	8.5	94.2%	10.6	12.0%
Боловсруулах ажүйлдвэр	284.8	2,137.1	306.9	2,369.1	22.2	7.8%	232.0	10.9%

Эх сурвалж: УСХ

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны 8 сарын гүйцэтгэлээр **11.4** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.5(15.5%)** их наяд төгрөгөөр өслөө. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл **8.3** их наядтөгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.2 (17.2%)** их наяд төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **1.2(49.2%)** их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар **72.7** хувийг эзэлж байна.

II.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

тэрбум төгрөг

Салбар	2018		2019			Өөрчлөлт			
	VIII	I-VIII	VIII	I-VIII	Гад-дад	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9	10
Нийтдүн	1,387.6	11,424.6	1,715.7	13,451.7	9,472.7	328.2	23.6%	2,027.1	17.7%
Уулуурхай, олборлохажүйлдвэр	907.7	7,836.2	1,187.0	9,377.2	8,000.7	279.3	30.8%	1,541.0	19.7%
Нүүрсолборлолт	225.0	2,519.2	447.0	3,520.3	3,221.0	222.1	98.7%	1,001.1	39.7%
Газрынтосолборлолт	88.6	696.3	81.2	637.9	637.9	-7.4	-8.4%	-58.4	-8.4%
Металлынхүдэрлборлолт	584.5	4,527.7	641.9	5,085.7	4,059.8	57.3	9.8%	558.0	12.3%
БусадАМолборлолт	9.6	92.9	16.9	133.3	82.0	7.3	76.4%	7.3	43.5%
Боловсруулах ажүйлдвэр	413.8	2,910.7	451.0	3,310.6	1,472.0	37.2	9.0%	399.9	13.7%

Эх сурвалж: УСХ

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2019 оны эхний 8 сарын байдлаар **13.5** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **2.0(17.7%)** их наяд төгрөгөөр өслөө. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **9.4** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.5(19.7%)** их наядтөгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **1.0(39.7%)** их наяд төгрөгөөр, металлын хүдэр олборлолт **558.0(12.3%)** тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс **9.5(70.4%)** их наядтөгрөг, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүнээс **8.0(59.5%)** их наяд төгрөгийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд тус тус борлуулсан байна.

III. ГАДААД ХУДАЛДАА

Гадаадхудалдаанынийтбарааэргэлт 2019 оныэхний8сарын байдлаар **9.5**тэрбум ам.доллартхүрчөнгөрсөнономөнүеийнхээс**1.0(11.9%)**тэрбум ам.доллараарөссөнбайна. Экспортимпортоосдавамгайлжэкспорт, импортынзөрүү**1.3**тэрбум ам.доллараарэрэггарсанбайна.

	Жилээр			Өөрчлөлт				I-VIII сар			Өөрчлөлт			
	2016	2017	2018	2017/2016		2018/2017		2017	2018	2019	2018/2017		2019/2018	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,274	10,536	12,887	2,262	27%	2,351	22%	6,857	8,473	9,478	1,617	24%	1,005	12%
Экспорт	4,916	6,201	7,012	1,284	26%	811	13%	4,102	4,671	5,387	569	14%	716	15%
Импорт	3,358	4,335	5,875	977	29%	1,540	36%	2,754	3,802	4,091	1,048	38%	289	8%
Тэнцэл	1,558	1,865	1,137	307		-728	-39%	1,348	869	1,296	-479	-36%	427	49%

III.1. ЭКСПОРТ

Экспорт**5.4**тэрбум ам.доллартхүрчөнгөрсөнономөнүеийнгүйцэтгэлээс**715.8(15.3%)** саяам.доллараарөссөнбайна.

Төмрийнхүдэр, чулуунүүрс, зэсийнбаяжмал, цайрынбаяжмал, жонш, молибденийбаяжмал, боловсруулаагүйнефтьзэрэгүүлуурхайнбүтээгдэхүүнньэрдэсбүтээгдэхүүнийэкспортын**98.5**хувь буюунийтэкспортын**81.3**хувийггэзлэжбайна.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт

№	Үзүүлэлт	Хэмжихнэгж	2018 I-VIII		2019 I-VIII		Өөрчлөлт			
			Тоохэмжэ	Үнийндүн	Тоохэмжэ	Үнийндүн	Тоохэмжэ	Хувь	Үнийндүн	Хувь
1	Чулуунүүрс	саятн/сая \$	23.49	1,837.0	24.92	2,131.8	1.44	6.1%	294.8	16.0%
2	Зэсийнхүдэр, баяжмал	мян.тн/сая \$	959.51	1,328.2	981.86	1,328.7	22.36	2.3%	0.6	0.0%
3	Боловсруулаагүйнефть	саябар/сая \$	4.39	287.0	4.29	241.0	-0.10	-2.2%	-46.0	-16.0%
4	Төмрийнхүдэр, баяжмал	саятн/сая \$	4.59	210.3	5.55	378.7	0.96	21.0%	168.4	80.1%
5	Хайлууржонш	мян.тн/сая \$	289.07	97.0	420.92	132.4	131.84	45.6%	35.4	36.5%
6	Цайрынхүдэр, баяжмал	мян.тн/сая \$	81.24	138.5	90.66	132.3	9.42	11.6%	-6.2	-4.5%
7	Молибденийхүдэр, баяжмал	мян.тн/сая \$	3.95	31.7	3.73	32.8	-0.22	-5.6%	1.0	3.3%
8	Хартугалганыхүдэр, баяжмал	мян.тн/сая \$	12.38	31.8	15.79	34.3	3.41	27.6%	2.5	7.8%
9	Цагаантугалганыхүдэр, баяжмал	тн/сая \$	25.09	0.3	39.13	0.6	14.04	56.0%	0.3	84.2%
10	Гянтболдынхүдэр, баяжмал	тн/сая \$	375.79	4.3	373.42	4.1	-2.37	-0.6%	-0.1	-3.1%
11	Боловсруулаагүйбуюуухагасб оловсруулсаналт	тн/сая \$	3.43	144.5	7.46	344.3	4.03	117.5%	199.8	138.3%

Эх сурвалж: ГЕГ

Чулуун нүүрсний экспорт 2019 оны эхний 8 сард **2,131.8** сая ам.долларын **24.9** сая тн чулуун нүүрс экспортолсоныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үнийн дүнгээр **294.7** сая ам.доллараар, тоо хэмжээний хувьд **1.4** сая тн-оор тус тус их байна. 2018 оны мөн үед 1 тн нүүрсний хилийн дундаж үнэ **78.2** ам.доллар байсан бол энэ онд **85.5** ам.доллар болж өсчээ. Чулуун нүүрсний **98.1** хувийг БНХАУ руу гаргасан байна.

Зэсийн баяжмалын экспорт 2019 оны эхний 8 сард **981.9** мян.тн-ыг экспортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **22.4** мян.тн-оор их байна. 2018 оны эхний 8 сард зэсийн баяжмалын экспорт үнийн дүнгээр **1,328.2** сая ам.доллар байсан бол тайлант сард **1,328.7** сая ам.доллар болжээ.

Төмрийн хүдрийн экспорт 2019 оны эхний 8 сард **5,554.0** мян.тн буюу **378.7** сая ам.долларт хүрсэн байна. 2018 оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад уг бүтээгдэхүүний экспорт **962.6** мян.тн-оор, үнийн дүн нь **168.4** сая ам.доллараар тус тус өсчээ. 1 тн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ **68.2** ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **22.4** ам.доллараар өссөн байна.

Боловсруулаагүй нефтийн экспорт 2019 оны эхний 8 сард **4,290.5** мян.бар буюу **240.9** сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **97.8** мян.бар-иар, үнийн дүнгээр **46.0** сая ам.доллараар тус тус бага байна. 1 барнефтийн хилийн дундаж үнэ **65.4** ам.доллар байсан бол тайланд хугацаанд **56.2** ам.доллар болж буурчээ.

Цайрын баяжмалын экспорт 2019 оны эхний 8 сард **90.7** мян.тн цайрын баяжмалын 1 тн-ыг дунджаар **1,459.0** ам.доллараар экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хилийн дундаж үнэ **245.8** ам.доллараар буурсан байна. Цайрын баяжмалын экспорт үнийн дүнгээр **132.3** сая ам.доллар болж, өнгөрсөн оныхоос **6.2** сая ам.доллараар буурчээ.

Хайлуур жоншны экспорт 2019 оны эхний 8 сард **132.4** сая ам.долларын **420.9** мян.тн-ыг экспортолсон нь 2018 оны мөн үеийн гүйцэтгэлээс **131.8** мян.тн-оор, үнийн дүнгээр **35.4** сая ам.доллараар тус тус өссөн байна. Жоншны экспортын дундаж үнэ **314.5** ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **21.0** ам.доллараар буурсан байна. Хайлуур жоншны 27.6 хувийг ОХУ руу, 72.1 хувийг БНХАУ руу тус тус экспортолсон байна.

Молибдений баяжмалын экспорт 2019 оны эхний 8 сард **32.8** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **1.0** сая ам.доллараар өссөн байна. Тус бүтээгдэхүүний 1 тн-ны экспортын хилийн дундаж үнэ **8,041.8** ам.доллараас **8,801.1** ам.долларт хүрч, **759.3** ам.доллараар өсчээ. 2019 оны эхний 8 сард **3,725.0** тн-ыг экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс **221.4** тн-оор бага байна. Молибдений баяжмалын 69.7 хувийг БНХАУ руу гаргасан байна.

Алтны экспорт 2019 оны эхний 8 сард **7,464.5** кг алт экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **4,032.6** кг-аар их байна. Алтны экспортын дундаж үнэ 2018 оны мөн үед **42,104.9** ам.доллар байсан бол энэ онд **46,121.4** ам.доллар болж **4,016.5** ам.доллараар өссөн байна. Алтны экспорт үнийн дүнгээр **344.3** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс **199.8** сая ам.доллараар өсчээ.

III.2. ИМПОРТ

Импорт **4.1** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **289.2** (**7.6%**) сая ам.доллараар өссөн байна.

Эрдэс бүтээгдэхүүний импорт **910.9** сая ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс **57.2** сая ам.доллараар буюу **6.7** хувиар өслөө. Эрдэс бүтээгдэхүүний импортын **84.7** хувийг нефтийн бүтээгдэхүүн эзлэж байна. 2019 оны эхний 8 сард **771.8** сая ам.долларын **1,226.4** мян.тн нефтийн бүтээгдэхүүн импортлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **190.0** мян.тн-оор, үүнийн дүнгээр **62.0** сая ам.доллараар тус тус өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын **87.9** хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний **32.1** хувийг автобензин, **67.9** хувийг дизель түлшний импорт эзэлж байна.

Автобензины импорт 2019 оны эхний 8 сард **363.7** мян.тн автобензин импортлосон нь 2018 оны мөн үеийн дүнгээс **86.7** мян.тн-оор их байна. 2018 оны мөн үед 1 тн автобензины импортын дундаж үнэ **698.5** ам.доллар байсан бол 2019 оны эхний 8 сард **598.5** ам.доллар болж **14.3** хувиар буурсан байна.

Дизель түлшний импорт 2019 оны эхний 8 сард **745.3** мян.тн болж 2018 оны мөн үеийн гүйцэтгэлээс **192.0** мян.тн-оор өссөн байна. 2018 оны эхний 8 сард 1 тн дизель түлшний импортын дундаж үнэ **653.4** ам.доллар байсан бол энэ онд **617.9** ам.долларт хүрч **35.5** ам.доллар буюу **5.4** хувиар буурсан байна. Дизелийн түлшний импорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **99.0** сая ам.доллараар нэмэгджээ.

--- оОо ---